

8

ХҮМҮН КАПИТАЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОНОЛЫН АСУУДАЛД

Д.Хишгээ

Хүмүн капиталын хөрөнгө оруулалт улс орнуудын микро болон макро түвшний өрсөлдөх чадварыг сайжруулах болон эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх чухал хүчин зүйлсийн нэг болж байна. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нэг нөхцөл бол хүмүн капиталыг бий болгон хуримтлуулах, хадгалах явдал мөн. Орчин үед мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, дадлагажуулах улмаар сурч боловсрох процессийг системтэй, тасралтгүй зохион байгуулж, мэдлэг чадварыг нь байнга дээшлүүлэх асуудлыг аливаа улс орон эдийн засгийн хөгжлийн гол чиг шугам болгож байна.

Өнөөдөр улс орны боловсролын системд зарцуулах засгийн газрын зардал өсөхийн зэрэгцээ аж ахуйн нэгж байгууллагууд, пүүсүүд өөрийн ажилчид боловсон хүчнийхээ мэргэжил боловсролыг дээшлүүлэх талаар системтэй, төлөвлөгөөтэй бодлого явуулж байна. Иймээс боловсон хүчний сургалтанд зориулсан зардлыг ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлд зарцуулж байгаа зардал төдийгүй үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн урт хугацааны хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлагатай холбон үзэх болжээ.

Тухайн улс орны эдийн засгийн хөгжилд биет капиталын хөрөнгө оруулалтаас гадна боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, урлаг соёл гэх мэт хүмүн капиталын салбарт зориулан их хэмжээний хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлага байгаа нь дэлхийн практикаас харагдаж байна.

Шинжлэх ухааны салбарт оруулсан хөрөнгө оруулалтын үр дүн нь биет капиталын хөрөнгө оруулалттай тэнцүү хэмжээний ач холбогдолтой болж байгааг эрдэмтэд тэмдэглэж байна.

Монгол улс тэрчлэн Оросын Холбооны улсын хувьд зах зээлийн эдийн засагт шилжсэнээр өндөр мэргэжлийн маш олон тооны боловсон хүчний

хуримтлуулсан мэдлэг чадварыг ашиглаж чадаагүй нь нөхөж болшгүй хохирол болсон.

Урьд нь хуримтлагдсан улс орны оюуны болон мэргэжлийн потенциалыг бүрэн ашиглах, шинээр бүрэлдсэн хүмүн капиталын хуримтлалыг цаашид хадгалах асуудал чухал юм. Иймд хүмүн капиталын хөрөнгө оруулалтын бүтэц, динамик процессийг шинжлэн дүгнэх шаардлага зүй ёсоор гарч байна. Эдийн засагчид хүмүн капиталын хуримтлалын үйл явцыг судлахдаа:

- Өмнөх үеийн залгамж холбооны тасралтгүй чанар
- Шинээр бий болж байгаа мэргэжил, мэдлэгийн төлөвшлийн хурд
- Даяаршил, мэдээллийн нөхцөлд ирээдүйн мэргэжлийн чиг баримжааг зөв тодорхойлох зэрэг асуудлуудыг анхааралдаа авдаг.

Манай орны хувьд хүний хөгжлийн үзэл баримтлал цоо шинэ зүйл биш юм. Энэ чиглэлээр багш нар сурах бичиг гаргаж, эрдэмтэд хүний хөгжлийн илтгэлийг бичихэд оролцож судалгаа шинжилгээ хийж байна. Харин хүмүн капиталын хөрөнгө оруулалтын асуудал манай эдийн засагчдын хувьд харьцангуй шинэ ойлголт болон гарч ирж байна.

Хүний хөгжлийн үзэл баримтлалаар эдийн засгийн өсөлт бол хөгжлийн зорилго бус харин хүний хөгжилд хүрэх арга зам юм. Гэтэл хүмүн капиталын хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч гол хүчин зүйлсийн нэг юм. Иймээс илтгэхдээ хүмүн капиталын мөн чанар, хүмүн капиталын хөрөнгө оруулалтын талаарх асуудлуудыг нэгтгэн дүгнэхийг оролдлоо.

Нэг. Хүмүн капиталын мөн чанар

Хүмүн капиталын онолын хөгжлөөс

Хүний бүтээх чадварыг бүрдүүлж бий болгох түүнийг нийгэм эдийн засгийн системд эзлэх байр суурийг нь тодорхойлох асуудлууд эдийн засагчид, судлаачдын анхаарлын төвд байсаар ирсэн. Бүр XVIII зуунд “Үндэстнүүдийн баялаг” бүтээлдээ А.Смит баялагыг бүтээхэд чухамхүү ажилчин, түүний дадал туршлага, ур чадвар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ. Мөн хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт нь юуны өмнө ажилчны авъяас чадварын өсөлтөөс дараа нь машин тоног төхөөрөмжийн сайжралтаас хамаарна гэж тэмдэглэжээ.

А.Смит үндсэн капиталын бүрэлдэхүүнд машин, хөдөлмөрийн багаж, зэвсэг, барилга байгууламж, газрын зэрэгцээ тухайн орны бүх хүн амын хөдөлмөрлөх чадварыг багтаасан байдаг. Тэрээр хүний боловсролд чухал ач холбогдол өгч түүнийг улс орны баялагыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх нэг гол төлөөлөгч Д.Рикардо хүлээн зөвшөөрч байв.

Д.Рикардо нийгэм эдийн засгийн хөгжлөөрөө улс орнуудын хоцрогдож байгаагийн нэг шалтгаан нь бүх давхаргын боловсролын хоцрогдол мөн гэж үзэж байсан.

Эдийн засгийн шинжлэх ухаанд XIX зууны сүүл XX зууны эхэн үед хувь хүний байгалийн мөн чанар болох хүний бүтээх чадварыг тодорхойлсон цоо шинэ үзэл баримтлалын чиглэлүүд дахин гарч ирсэн. Эдгээрээс нилээн өргөн хүрээтэй тархсан хоёр чиглэл байна.

1-рт: Хүн ба хүний бүтээх чадвар бол капитал мөн.

2-рт: Хүн өөрөө капитал юм.

Нэгдүгээр чиглэлийн төлөөлөгчдийн нэг С.Миль хүмүүн капитал нь хувь хүн бус харин түүний өвлөгдөн ирсэн ба олж авсан ур чадвар юм гэж үзэж байсан. Эдийн засагч У.Рошер, Ф. Лист нар хүний олж авсан хөдөлмөрлөх, боловсрох мэргэжлээ дээшлүүлэх чадварыг нь капитал юм гэж тодорхойлсон. Хүмүүн капиталын онолыг цаашид хөгжүүлсэн эрдэмтэн бол А.Маршал юм. Тэрээр хүний хөдөлмөрийн үр дүнд бий болж байгаа цалин болон бусад орлогууд нь капиталын хүүтэй адил төстэй бие хүнийг өөрийг нь капитал гэж үзэж байсан. II чиглэлийн төлөөлөгчид нь Л.Вальрас, Ж.Кларк, И.Фишер нар юм. Тухайлбал бие хүний боловсрол мэдлэгээ дээшлүүлэхэд хөрөнгө оруулах замаар орлогоо нэмэгдүүлэх сонирхол биет капиталын хуримтлалтай ижил утгатай ойлголт юм гэжээ. XX зууны эхний арваад жил хүмүүн капиталын онолын асуудлаар судалгаа шинжилгээ нэг их хийгдээгүй байна. Гэвч шинжлэх ухаан, техникийн үсрэнгүй хөгжлийн нөлөөгөөр нийгмийн үйлдвэрлэх хүчний бүтцэд гүнзгий өөрчлөлт гарч хөдөлмөрийн агуулга, шинж чанар өөрчлөгдөж ирлээ. Иймээс хүмүүн капиталын онол ч шинэ агуулгаар баяжин хөгжиж ирсэн.

Кембелл / 1970-аад онд Калифорний их сургуулийн эдийн засгийн төвийн захирал / хэлэхдээ: Орчин үеийн эдийн засгийн хурдацтай хөгжлийн гол нөөц нь технологийн шинэ санаа өөрөөр хэлбэл энэхүү шинэ санааг амьдралд хэрэгжүүлж чадах хүмүүсийн бүтээлч идэвхи, өндөр мэргэжил юм гэж тэмдэглэсэн. Үүнтэй холбоотойгоор улс орнууд 1960-аад оноос бүтээлч хөдөлмөрийн нөөцийг бий болгох асуудлыг төрийн бодлогын хүрээнд авч үзэх болсон. Энэ үед аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад хүнд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжсэн хууль дүрмийг олноор гаргах болсон байна. XX зуунд хүмүүн капиталын онолыг дахин сэргээж авч үзсэн эрдэмтэн бол Гарвардын их сургуулийн ажилтан Ж. Уолш юм. Тэрээр АНУ-ийн үндэсний орлогын түвшинд мэргэжлийн боловсролын үзүүлэх нөлөөг хүмүүн капиталын онолыг ашиглан тооцоолон гаргасан байна. Америкийн эрдэмтэн “Чукаго-ын сургуулийн төлөөлөгч” Т.Шульцийг орчин үеийн хүмүүн капиталын онолын үндэслэгч гэж үздэг бөгөөд тэрээр сонгодог онолын гол төлөөлөгчдийн нэг юм. Т.Шульд 1961 онд хэвлүүлсэн “Хүмүүн капиталын хөрөнгө оруулалт” бүтээлдээ хүмүүн капиталын онолын асуудлыг нэгтгэн дүгнэжээ.

Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын талаар түүний их сургуулийн ангийн анд болох Г. Беккер ба 1975 онд нийтлүүлсэн “Хүмүүн капиталын онолын болон эмпирик шинжилгээ” хэмээх бүтээлд уг онолын микро эдийн засгийн үндсийг боловсруулснаас гадна дараа дараагийн

судлаачдын баримталвал зохих үндсэн загвар, системийг гаргаж өгсөн байна.

Г.Беккерийн судалгааны онцлог нь нийгмийн амьдралын олон талт үйл явцад эдийн засгийн шинжилгээний аргыг хэрэглэсэн явдал юм. Эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсролд хөрөнгө оруулалт хийхдээ түүнтэй ижил төстэй бусад зардлуудаас олох, ашгийн нормтой нь харьцуулж тооцоолдогтой адил тооцоо хийж байж шийдвэр гаргана гэжээ. Тэрээр хүмүүн капиталын шинэ онолыг үндэслэхийн зэрэгцээ боловсролын эдийн засгийн үр ашгийг статистик аргаар тооцоолсон байна. Г.Шульд, Г.Беккер нарын эдийн засгийн шинжлэх ухаанд тэр тусмаа хүмүүн капиталын онолд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн Нобелийн шагнал олгожээ. Эдгээр эрдэмтэд хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын ач холбогдлыг тодорхойлоод зогсоогүй түүний аж ахуйн амьдралд ямар нөлөөтэй болохыг тооцоолон гаргасан шинэ сонгодог онолын гол төлөөлөгчид юм.

XX зууны 50-иад оны сүүлчээс барууны эдийн засгийн шинжлэх ухаанд хүмүүн капиталын онолын шинэ чиглэл үүсч хөгжиж ирсэн байна. Үүнийг өргөтгөсөн концепци гэж нэрлэдэг бөгөөд гол төлөөлөгч нь Америкийн эдийн засагч Ж.Кендрик юм. Түүний онолоор “Хүмүүн капитал нь тодорхой хугацааны явцад бүтээгдэхүүн үйлдвэрлэж бүх төрлийн орлого олох чадвар” юм гэжээ. Сүүлийн үед хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын талаар Орос, Япон, Америк зэрэг орны эрдэмтэд судалгаа, шинжилгээний бүтээл өргөнөөр туурвиж байгаа бөгөөд манай орны хувьд хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын талаар тодорхой судалгааны бүтээл гараагүй байна. Харин хүмүүн капитал эдийн засгийн өсөлтийн нэг хүчин зүйл болох талаар МУИС-Эдийн засгийн онолын тэнхимийн багш Б.Алтанцэцэг судалгаа хийсэн байдаг.

Хүмүүн капиталын мөн чанар

Хүмүүн капиталын мөн чанарын талаар одоо болтол нэгдсэн ойлголт бий болж чадаагүй байна. Эдийн засгийн шинжлэх ухааны хөгжлийн явцад эрдэмтэд хүмүүн капиталын мөн чанарыг янз бүрээр тодорхойлж ирсэн байна. Хүмүүн капиталын дотоод бүтцийн талаар эдийн засагчид нэгдсэн ойлголтонд хүрээгүй байгаа юм. Хүмүүн капиталын бүтцэд нүүс, бусад хүмүүст үнэнч байх хэн нэгэнд ам тангараг өгөх зэрэг ойлголт ч багтана гэж зарим судлаач нар үздэг байна. Өөрөөр хэлбэл хүмүүн капиталыг эзэмшигч өөрийн капиталын тодорхой хэсгийг ажил олгогч нүүс, эсвэл өөр хүнд шилжүүлнэ. Ингэснээр тухайн үйлдвэр, аж ахуйн газрын нийт капиталыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Орчин үед хүмүүн капиталын мөн чанарыг хоёр янзаар тодорхойлж байна.

Нэгдүгээрт: Хүмүүн капиталд хүний чадвар төдийгүй хүн өөрөө байгалийн амьтан болохын хувьд багтана үзсэн байдаг. Төлөөлөгч нь Ж.Кендрик бөгөөд биет ба биет бус капитал гэж хувааж үзсэний үндсэн дээр тодорхойлсон байна.

Хоёрдугаарт: Хүмүн капитал нь орчин үеийн нийгмийн үйлдвэрлэлийн үндсэн харилцааг илэрхийлэгч юм. Тиймээс үйлдвэрлэл – хэрэглээ ба оюуны гэсэн хоёр хэлбэртэй байна гэж үзжээ. Төлөөлөгч нь М.М.Критский болно.

Орчин үеийн хүмүн капиталын онолын арга зүйн үндэс нь хүмүн капиталыг биет капиталтай адилтган үзэж загварчлах явдал гэж үзэх хандлага түгээмэл болжээ. Энэ загварчлалын дагуу хүмүн капиталыг судлахдаа хүний биет болон моралын элэгдэл, хорогдолын шимтгэл, ашиглалтын хугацаа, хүүгийн түвшнээс хамааралтай орлогын капитал зэрэг ойлголтуудыг ашиглах боломжтой болж байгаа юм. Хүний мэдлэг, дадал чадвар эрүүл мэнд зэрэг нь биет капиталын адил үйлдвэрлэлийн процессд өртөг бүтээдэг мөн хуримтлагдах чадвартай энэ шинж чанар нь биет капиталын түгээмэл шинж юм.

Хүмүн капиталыг юуны өмнө дараах байдлаар ангилна.:

Хүмүн капиталыг өөрийг нь нөхөн үйлдвэрлэхэд оролцдог бие хүний цогц чанар үйлдвэрлэхэд оролцдог онцгой капитал

Өөр бүтээгдэхүүн үйлчилгээ бие болгоход оролцдог капитал гэж үздэг.

Г.Беккер хүмүн капитал гэсэн ойлголтонд “Ерөнхий хүмүн капитал” –аас гадна мэргэжлийн бэлтгэлийн үр дүнд олж авсан мэдлэг дадал туршлагыг багтаасан байдаг. Харин эрдэмтэн У.Боуэн тодорхойлохдоо: “Хүмүн капитал нь тодорхой хугацааны туршид бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэх зорилгоор ашиглагдаж болох хүнд байгаа мэдлэг, дадал туршлага, энерги, хүсэл эрмэлзлэлийн нийлбэр юм” гэжээ. Эдийн засагч Эдвин Ж.Делан тодорхойлохдоо: “Хүмүн капитал нь практик туршилт, боловсрол сургалтын явцад олж авдаг хүний оюуны чадвар” гэж үзжээ.

Дээрх тодорхойлолтуудаас харахад хүмүн капиталын мөн чанарыг.

-Нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн аль нэгэн салбарт зорилго чиглэлтэйгээр ашиглагдан хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөнд шууд нөлөөлөх хүний эрүүл мэнд, мэдлэг, дадал туршлага, ур чадвар, хүсэл эрмэлзлэл зэрэг бие хүний хуримтлуулсан бүх чадваруудын нийлбэр юм. Энэ нь капитал болон хувирна. гэсэн дэлгэрэнгүй тодорхойлолтыг өгч болох юм.

Хүмүн капиталыг эрүүл биетэй, ухаан саруул хувь хүний чадвар, дадал туршлага арга барилын цогц нийлбэр гэж дийлэнх судлаачид үздэг болохыг тэмдэглэж байна. Зах зээлийн эдийн засагт хөдөлмөрийн чадвар хүмүн капиталын хэлбэрээр хэрэгждэг байна. Харин хүний чадвар нь түүнийг эзэмшигчийн болон хүрээлэн хүмүүсийн зорилго чиглэл бүхий хүч хөдөлмөрийн үр дүн юм. Худалдаж басхүү худалдан авдаг хөлсний хөдөлмөрөөс хүмүн капитал нь өөрөө бүрэлдэн тогтох, хөгжих явцдаа үндсэн капиталын адил урьдчилгаа, нөхөн сэргээгдэх тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардаж байдгаараа ялгаатай.

Хүмүн капитал нь бие хүнээс өөрөөс нь салшгүй бөгөөд ямагт хуримтлагдаж байх чадвар бүхий үйлдвэрлэлийн удаан хугацааны ашиглалтын актив мөн.


Хүмүн капиталыг хувь хүнээс салгаж ойлгохын аргагүй учраас түүнийг бэлэглэх, барьцаанд тавих, гэрээслэн үлдээх боломжгүй гэхдээ хүмүн капиталыг эзэмшигчээс огт салахгүй зүйл гэж бас ойлгож болохгүй. Хүмүн капитал бүрэн элэгдэлд орохоос өмнө моралын элэгдэлд эхлээд ордог. Нийгмийн баялаг бүтээхэд нөлөөлж байгаа хэлбэрээс нь хамааран хүмүн капиталыг:

- Хэрэглээний хүмүн капитал
- Үйлдвэрлэлийн хүмүн капитал гэж хувааж үздэг.

Хэрэглээний хүмүн капитал нь хувь хүнд өөрт нь шууд зарцуулагдах капитал болно. Энэ нь хүн өөрийгөө бүтээлчээр хөгжүүлэх, ингэснээр хэрэгцээгээ хангах шинэ арга барилыг бий болгохтой холбоотой юм.

Үйлдвэрлэлийн хүмүн капитал нь нийгмийн хэрэглээнд зориулагдан ашиглагдаж байгаа капитал юм. Үйлдвэрлэлийн процесст шууд хэрэглэгдэх шинжлэх ухааны мэдлэгийг эзэмшсэнээр хүмүн капитал нь нийгмийн үйлдвэрлэлийг дээшлүүлэх гол хүчин зүйл болно.

Хүмүн капиталыг ямар хэлбэрт хувирч байгаа нь түүнийг ангилах нэг шалгуур болж өгдөг. Үүнийг дараах зургаар харуулж болно.



Үйлдвэрлэлийн процесст оролцох боломжийн үүднээс хүмүн капиталыг авч үзэхдээ нэг талаас тухайн ажилчны эрүүл мэнд, мэргэжлийн түвшин, нөгөө талаас уг ажилчны өөрийн нүүс компанидаа хир зэрэг үнэнч байгааг нь хүмүн капиталын мөн чанарын онцлог гэж ойлгож болно. Хүмүн капиталыг онолын хувьд янз бүрээр тодорхойлж болдог ч тухайн бие хүн бодит амьдрал дээр төрөхөөс эхлэн нас барах хүртлээ амьдралын хэд хэдэн үе шатыг туулна. Эдгээр үе шатууд нь бие биенээсээ нас, боловсрол, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцох байдал, шинжлэх

ухааны үйл ажиллагаа, эрүүл мэндийн байдлаар тус тус ялгаатай байдаг. Иймээс хүмүүн капитал бүрэлдэн тогтоход үе шат бүхий онцлогт тохирсон хөрөнгө оруулалт шаардагдана. Хүний эрүүл мэнд, мэргэжлийн ур чадвар, өгсөн даалгаварыг хэрхэн гүйцэтгэж байгаа болон тухайн ажлыг хийх хүсэл эрмэлзлэл зэрэг нь хүмүүн капиталын гол шалгуур үзүүлэлт мөн.

Эндээс үндэслэн хүмүүн капиталын нөхөн үйлдвэрлэлийг дараах үе шатуудад хувааж үздэг.

Төрөөсөөс эхлэн ерөнхий ба мэргэжлийн боловсрол олж авах хугацаа

Ажиллах хүчний бүрэлдэхүүнд анхлан орох үе

Үр ашигтай тогтвортой ажиллах үе

Хөдөлмөрийн чадвар аажмаар буурч, ажлаас гарах хүртэлх үе

Тэтгэврийн үе

Нөхөн үйлдвэрлэлийн **нэгдүгээр шат** байгалийн буюу инстинктийн ухамсар давамгайлсан хүмүүн капитал юм. Хүмүүс сургуульд суралцан дараа нь мэргэжил эзэмшин өөртөө хөрөнгө оруулалт хийж тодорхой хэмжээний дадал, чадвар хуримтлуулна.

Хоёрдугаар шатанд хуримтлуулсан дадал чадвар нь хөдөлмөрийн үйл ажиллагааны үр дүнд бодитой төлөвшино.

Гуравдугаар шатанд байгалиас заяасан бие махбодын эрүүл мэнд, чадвар болон олж авсан мэдлэг боловсролыг бүрэн дүүрэн ашиглана. Энэ үед ажиллах чадварыг сайжруулах гол үндсэн хүчин зүйл болох эрүүл мэндийн / эмнэлгийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх эмчилгээ, рашаан сувилал, орон сууцны нөхцлөө сайжруулах / зардалд хөрөнгө оруулах шаардлагатай болдог байна. Түүнчлэн хүмүүсийн шилжилт хөдөлгөөн түүнтэй холбоотой дасан зохицох чадварт зориулсан хөрөнгө оруулалт багагүй чухал үүрэгтэй. Хөдөлмөрийн хөлсөө нэмэгдүүлэх зорилгоор өөр газар, нутаг, өөр улс руу шилжилт хийх нь хүмүүн капиталын хувьд зайлшгүй.

Хүний амьжиргааны түвшин аж ахуйн үйл ажиллагааны шинэ нөхцөл байдалд дасах чадвараас хамааран хүмүүн капитал өөрчлөгдөж байдаг. Энэ дасах чадвар нь хүний оюуны болон биеийн хүчний чадал, боловсрол мэргэжлийн түвшинтэй салшгүй холбоотой байдаг. Харин хүмүүн капиталын циклийг хүний амьдралын циклтэй уялдуулан авч үзвэл маш сонирхолтой байх нь дамжиггүй.

Хоёр. Хүмүүн капиталын хөрөнгө оруулалт

2.1 Хүмүүн капиталын хөрөнгө оруулалт

Хүмүүн капиталыг биет капиталтай адилтган үзэх зарчмын дагуу хөрөнгө оруулалтын хувьд бас адил бөгөөд ялгаатай талуудтай. Хүмүүн ба биет капиталын хөрөнгө оруулалтын адил талууд:

1. Аль аль нь өнөөгийн хэрэглэгээнд шууд ашиглаж бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэхэд зарцуулагдах алдагдсан эдийн засгийн ноогийн зарцуулалтын үр дүнд хуримтлагдана.

2. Удаан хугацаанд ашиглагдах явцад ашиг орлого авчирна.

3. Амьдралын хугацаа нь хязгаарлагдмал өөрөөр хэлбэл машин тоног төхөөрөмж элэгдэнэ, эвдэрнэ хүн нас барна.

4. Аль аль нь биет ба хоцрогдлын элэгдэлд орно. Хүмүүн капитал нь бие капиталаас дараах нь зүйлүүд дээр ялгаатай.

1. Хүмүүн капитал түүнийг тээгч буюу хүнтэй ямагт хамт салшгүй оршино.

2. Хүмүүн капиталд оруулсан хөрөнгө оруулалт харьцангуй урт хугацаанд эдийн засгийн болон нийгмийн үр ашгаа өгнө.

3. Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын хугацаа биет капиталын хөрөнгө оруулалтын хугацаанаас урт байдаг тухайлбал 10-20 жилийн туршид үргэлжилдэг байна.

Дээрх ижил төстэй ба ялгаатай талуудыг үндэслэн хүмүүн капиталын хөрөнгө оруулалтыг дараах байдлаар тодорхойлж болох юм.

• Ирээдүйд тухайн хүний цалин орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн тодорхой зорилго бүхий бүх зардлуудыг хүмүүн капиталын хөрөнгө оруулалт гэнэ.

• Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд шууд нөлөөлдөг хүний мэдлэг, ур чадвар, дадал туршлагыг бий болгоход чиглэгдсэн зардлуудын нийлбэрийг хүмүүн капиталын хөрөнгө оруулалт гэнэ.

Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын хэмжээ хүн бүрт харилцан адилгүй байдаг. нь дараах зүйлүүдтэй холбоотой.:

• Субъектын (хувь хүний) чөлөөт сонголт

• Материаллаг болон оюуны хүсэл сонирхол

• Соёлын түвшин

• Эдийн засгийн нөхцөл бололцоо зэрэг хүчин зүйлүүдийн улмаас хүтүн капиталын хөрөнгө оруулалтын хэмжээ хүн бүрийн хувьд харилцан адилгүй байдаг. Энэ ялгаатай байдал нь цаашид хүмүүн капиталын өгөөж өөр байх нөхцлийг бүрдүүлж байна. Хүмүүн капиталыг ашигласаны үр дүнд хувь хүнд бий болсон бодит орлого, нөгөө талаар пүүс компанид оруулж байгаа түүний хувь нэмэр, бүтээлч хөдөлмөрийн хэмжээ нь өгөөжийг тодорхойлно.

Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг 3 төрөлд хуваан авч үздэг

- Хүмүүн капитал нь хувь хүнтэй салшгүй холбоотой учраас түүний хувийн өмч мөн. - -- Пүүс компани нь хүмүүн капиталыг сайтар ашиглахын үүднээс ямагт түүнийг хөгжүүлэхийн тулд тодорхой хөрөнгө гаргах ёстой.

- Орчин үед улс орнууд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаар тодорхой зорилго чиглэлтэй бодлого явуулах болсон тул засгийн газар, боловсрол эрүүл мэндэд тодорхой хөрөнгө зарцуулж байна. Иймээс хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь:

- Хувь хүний өөртөө оруулж байгаа хөрөнгө оруулалт
- Пүүс, компани, ажил олгогчоос оруулж байгаа хөрөнгө оруулалт
- Төрөөс нийгмийн хөгжлийн шаардлагын дагуу бүх нийтэд үзүүлдэг хөрөнгө оруулалт зэрэг болно.

Орлогын тэгш бус байдлаас шалтгаалан хүмүн капиталд оруулах хувийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр нийгмийн гишүүн бүрт боломжтой байж чаддаггүй болохыг анхаарах нь зүйтэй. Иймд бусад эх үүсвэрээс хөрөнгө оруулахдаа тухайн хувь хүний хүсэл, эрмэлзэл, чадавх чадвараас хамаарсан ялгавартай бодлого явуулах нь илүү өгөөжтэй гэж үздэг байна. Хүмүн капиталын хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцоолохдоо түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох шаардлагатай болдог.

Ялангуяа эдийн засгийн зөв шийдвэр гаргахаас юуны өмнө эхлэх ёстой. Хүмүн капиталын хөрөнгө оруулалт хийхийн тулд дараах зарчмуудыг баримтлах нь зүйтэй гэж эрдэмтэд тодорхойлсон байна.

Нэгдүгээр зарчим: Хязгаарлагдмал нөөц боломжийн нөхцөлд зөв шийдвэр гаргах анхны зарчим бол хамгийн бага зардлаар максимум үр дүнд хүрэх явдал юу. Энэ бол микро, макро түвшний эдийн засгийн гол зорилт мөн. Нөгөө талаас хөгжин дэвшиж байгаа хүн төрөлхтний хувьд чөлөөт сонголт хийх хувь хүний боломж маш өргөн болжээ.

Г.Беккер нийгмийн янз бүрийн хүрэн дэх хүмүүсийн үйл хөдлөлийг дараах байдлаар тайлбарлажээ.

Тэрээр "Хүмүүс хэдэн жил сурах ямар боловсрол эзэмших, хэдэн хүүхэдтэй байх, тэр ч байтугай гэмт хэрэг хийх үү үгүй юу гэдэг шийдвэр гаргах бүртээ зардлаа багасгах, ашгаа нэмэгдүүлэх гэсэн зарчмыг л баримталж байдаг байна" гэж тэмдэглэсэн байна. Энэ зарчим нь зах зээлийн нөхцөл дахь "Эдийн засгийн хүн" гэдэг ойлголтыг баталгаажуулж байна. Орчин үед хувь хүний эдийн засагт гүйцэтгэх үүргийг үнэлэх боломжтой болсон нь аливаа эдийн засагт хүмүн капиталын талаар зөв бодлого боловсруулах боломжийг олгож байна.

Хоёрдох зарчим: Хүмүн капиталын хөрөнгө оруулалтын оновчтой сонголт хийхэд боловсролын явцад олж авсан мэдлэг нь хувь хүнд үнэт зүйл байх ёстой гэсэн ойлголт юм. Удирдлагын талаар зөвлөлгөө өгдөг нэртэй мэргэжилтэн П.Драккерийн хэлснээр "Мэдлэг бол худалдан авагчийн бизнес иймээс хэрэглэгчид өөрт нь хэрэгцээг хангадаг үнэт зүйлс байх ёстой" ажээ. Иймээс "Үр дүнд чиглэсэн удирдлага" буюу хүнд оруулсан хөрөнгө оруулалт үр өгөөжтэй байх ёстой, хувь хүний мэдлэг нь өсөн нэмэгдэж өртөг бүтээх эх үүсвэр болсон капитал болон хувирч байдаг тул үнэт зүйл байх ёстой гэж тайлбарлажээ. Хүнд оруулсан хөрөнгийн үр өгөөжийг тодорхойлох капиталын ашгийн нормыг тооцохоос илүү төвөгтэй байдаг. Янз бүрийн замаар олж авсан төрөл бүрийн боловсролын орлого харилцан адилгүй бөгөөд одоо хүртэл нарийн тооцож чадаагүй байна.

Хүмүн капиталын үр ашгийг тооцоход хүндрэл учруулж байдаг шалтгаануудаас заримыг нь дурдвал: Хүмүн капиталын хуримтлалын процесс өөрөө зөрчилтэй үйл явц юм. Нэг талаас хүмүүс одоо ажил хийгээд орлого шууд олох уу? Эсвэл үргэлжлүүлэн суралцаад ирээдүйд илүү орлого олох уу гэдэг дээр маш зөв ухаалаг сонголт хийх хэрэгтэй болдог. Үүнийг шийдэхэд хариуцлагыг ухамсарласан нарийн тооцоо хийдэг байна. Ихэнх тохиолдолд энэ жишээн дээр одоо ажил хийхийг илүү сонгодог. Нөгөө талаас хүмүн капиталын үлэмж хэсэг нь хөдөлмөрийн үйл ажиллагааны үр дүнд бүрэлдэн тогтох бөгөөд үүнийг нарийвчлан тогтоох боломжгүй.

Тухайн нэг пүүс, компанийн хувьд боловсон хүчний хөрөнгө оруулалт урт хугацааны шинж чанартай байдаг. Гэхдээ америкийн компаниуд дээр хийсэн судалгаанаас үзэхэд зардлаа 2-4 жил буюу харьцангуй богино хугацаанд нөхөж чаддаг байхад бусад улсад тэр болгон ийм байж чаддаггүй бас компани бүрд өгөөжийн хугацаа харилцан адилгүй байдаг байна. Ялангуяа тухайн компанийн өндөр зардлаар бэлтгэсэн ажилтан оор компанид илүү цалинтай ажиллахаар явах нь пүүсийн хувьд алдагдал хүлээх нь тодорхой. Байдал хэдий ийм ч гэсэн хөгжингүй орнуудад пүүсүүд өөрийн ажилчдын мэргэжил боловсролд зориулсан зардал тасралтгүй нэмэгдсээр байна. Энэ нь пүүс компаниуд хүмүн капиталын хөрөнгө оруулалтын зардлаа байнга өсгөж байдаг зүй тогтол оршиж байгааг харуулж байна. Мөн пүүсүүд хүмүн капиталд хөрөнгө оруулах даа сургалтын дараах ажилчны ахиу бүтээмжийн өсөлт түүний ахиу цалингийн өсөлтөөс их байна. Харин энэ ахиу цалин нь өөр пүүсийн ахиу цалингаас их байх ёстой гэсэн зарчмыг баримталдаг. Иймээс ажилчин зөвхөн өөрийнхөө цалин, орлогын төлөө төдийгүй компанийн ашиг сонирхлын төлөө санаа зовох болж байгаа нь хүмүн капиталын тухайн пүүстэй тогтвортой ажиллах гол нөхцөл нь болж байна.

2.2 Хүмүн капиталын хөрөнгө оруулалтын төрлүүд

К.Макконелл, С.Брю нар экономиксийн сурах бичигтээ хүмүн капиталын хөрөнгө оруулалтын 3 үндсэн төрлийн зардал байдаг гэж дурьджээ. Үүнд:

- Боловсролын зардал - Мэргэжлийн боловсрол,
- Албан ба албан бус сургалт
- Ажлын газрын төлөвлөгөөт сургалтууд
- Эрүүл мэндийн зардал - Эмнэлгийн үйлчилгээ - Урьдчилан сэргийлэх үзлэг
- Рашаан сувилал
- Орон сууцны нөхцөл сайжруулах
- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний зардал - Улс хоорондын болон орон нутгийн доторх шилжилт
- Өндөр бүтээмжтэй ажил хайх
- Газар зүйн ашигтай байршил

Эдгээр хөрөнгө оруулалтын зардлын дотоод бүтцийг тодруулан авч үзье.

Нэг. Хүмүн капиталын боловсролд зориулсан хөрөнгө оруулалтын зардал Үйлдвэрлэлийн үйл явцад байнга ашиглагдаж байдаг тухайн ажилчны боловсролын зэрэг, мэргэжлийн ур чадвар, ажлын цагийн тоо зэрэг нь хүмүн капиталын чанарын болон тоон агуулгыг илэрхийлж байна.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаан дахь сургалтанд төсвөлөн зарцуулж байгаа зардал нь хүмүн капиталын хөрөнгө оруулалтын хамгийн чухал хэсэг гэж эдийн засагчид үздэг.

Пүүс компаниуд өөрийн боловсон хүчнийг бэлтгэх, мэргэжил болон мэргэшилээр ажилчидынхаа бүтцийг сайжруулах нь үйлдвэрийн ирээдүйн хөгжилтэй уялдаатай байдаг. Г.Беккер "Хүмүн капитал" номондоо хүний тусгай мэргэжлийн хөрөнгө оруулалт ба ерөнхий хөрөнгө оруулалтын хоорондын ялгааг тодорхойлсон. Тухайлбал тусгай мэргэжлийн хөрөнгө оруулалтын үр дүнд ажилчин зөвхөн тухайн пүүсийн ашиг сонирхлыг илэрхийлсэн мэдлэг туршлагатай болдог байна. Харин ерөнхий хөрөнгө оруулалтын үр дүнд ажилчин өөр аль ч салбарын пүүс компанид ажиллаж чадах мэдлэг дадалтай болдог. Хүмүн капиталын онолын хөгжлийн эхний арваад жил ерөнхий хөрөнгө оруулалтанд анхаарал төвлөрүүлж байсан бол сүүлийн жилүүдэд тусгай мэргэжлийн хөрөнгө оруулалтыг илүү сонирхох болсон байна. Тусгай хөрөнгө оруулалтын энэ зардал АНУ, Япон зэрэг хөгжингүй орнуудад маш хурдацтай өсч байна. Тэнд энэхүү зардлыг пүүс компани гаргадаг байна. Манай орны хувьд ийт төрлийн хөрөнгө оруулалтыг ихэвчлэн төрөөс хийдэг учраас хөрөнгө оруулалтын үр дүнгийн хяналт бараг байдаггүй байна.

Хүмүн капиталын боловсролд зориулж байгаа ерөнхий хөрөнгө оруулалтын зардал хуучин социалист байсан орнууд, ОХУ, манайд давамгайлах хандлага хэвээрээ байна. Боловсролд оруулж байгаа тусгай хөрөнгө оруулалтын зардлыг эцэг эхчүүд, төрөөс голчлон гаргаж цөөн тооны пүүс компани тусгай захиалгаар мэргэжилтэн бэлтгэж байна. Монгол орны хувьд тусгай хөрөнгө оруулалтыг пүүс компаниуд гаргахгүй байгаа учраас бэлтгэгдсэн мэргэжилтнүүд ажилгүй байхын зэрэгцээ хөрөнгө оруулалтын өгөөж бага байдаг. Хүний оюуны потенциал эдийн засгийн тодорхойлогч хүчин зүйл болж байгаа өнөө үед боловсролд зориулсан хөрөнгө оруулалтыг бүх эх үүсвэрээр нь нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хүмүн капиталын эрүүл мэндэд зориулсан хөрөнгө оруулалтын зардал


Эрдэмтний судалгаанаас үзэхэд хүний эрүүл мэндийн 8-10 хувь нь эрүүл мэндийн хамгааллаас 20 хувь нь экологийн нөхцлөөс, 20 хувь нь генетикийн хүчин зүйлээс 50 хувь нь тухайн хүний амьдралын хэв маягаас хамаарч байна гэсэн тооцоо гарчээ. Хамгийн их хувь эзэлж байгаа хүний амьдралын хэв маяг гэсэн ойлголтонд өдрийн дэглэм, ажил амралтаа зохицуулах чадвар зөв хооллох, муу зуршилаас хол байх биеийн тамир спортоор хичээллэх зэрэг ойлголт багтдаг. Хүний эрүүл саруул ажиллаж

амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд гарах бүх зардлыг хүмүн капиталын эрүүл мэндэд зориулсан хөрөнгө оруулалт гэж үздэг.

Гурав. Хүмүн капиталын шилжилт хөдөлгөөнд зориулсан хөрөнгө оруулалтын зардал

Өндөр хөгжилтэй улс оронд очиж ажиллах явдал дэлхий нийтийн түгээмэл үзэгдэл болжээ. Манай орны хувьд Япон, Солонгос зэрэг оронд олон мянган хүн ажиллаж байна. Түүнчлэн хөдөөгөөс хот суурин газар луу шилжих, хөдөлгөөн эрчимжиж хотууд томрон тэлж байна. Улаанбаатар Эрдэнэт, Дархан хотуудын хүн ам жил ирэх тусам нэмэгдсээр байна. Өндөр бүтээмжтэй ажил хайж шилжихээс гадна илүү тохь тухтай амьдрах зорилгоор газар зүйн ашигтай байрлал сонгон шилжих хөдөлгөөн хийдэг ажээ. Шилжих хөдөлгөөнтэй холбогдсон зардлыг хувь хүн өөрсдөө гаргаж байдаг учир хөрөнгө оруулалтын өгөөжийг өөрөө хүртэж, хариуцлагаа өөрөө хүлээж байдаг онцлогтой байна.

Түүнчлэн хүмүн капиталын хөрөнгө оруулалтын бусад зардалд шинжлэх ухааны суурь судалгаанд зориулсан зардлыг хамааруулдаг байна. Учир нь шинжлэх ухаан хөгжихийн хирээр үйлдвэрлэлд шинэ технологи бий болж хэрэглээний шинэ аргууд гарч аж ахуйн субъект болохын хувьд хүмүн капиталын оюуны потенциал агшуулгын хувьд өөрчлөгдөж байдаг. Мэдээллийн энэ эрин үед шинжлэх ухаан нь хүмүн капиталын онцгой төрлийн үүсгэвэр болж байна.



Дүгнэлт

Хүмүн капиталын талаар судалгаа бүтээл туурвиж нээлт хийсэн АНУ, Япон, Швед зэрэг орны эрдэмтэдийн бүтээлтэй танилцлаа. Хүмүн капиталын шинэ онолын зарим үзэл баримтлалд хувь хүний боловсрол мэдлэгийг чухалчлан авч үзсэн байна. Тухайлбал П.Драккер үзэхдээ

"Мэдлэг бол хүний цэвэр өөрийн нь нөөц юм. Тиймээс түүнийг ном сурах бичгээс авах боломжгүй. Ном сурах бичигт зөвхөн мэдээлэл агуулагдаж байх бөгөөд харин мэдлэг нь мэдээллийг тодорхой ажил хэрэг болгох хүний чадвар юм. Энэ чанар нь зөвхөн хүнд тухайлбал түүний уураг тархи, гарын ур чадварт оршдог" гэжээ.

Хүмүн капиталд оруулж байгаа хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлэх талаар Монгол орны нөхцөлд тохирсон оновчтой санал бодлого боловсруулах явдал зайлшгүй болжээ. Пүүс компанийн зүгээс хүмүн капиталд хөрөнгө оруулалт хийх явдлыг аль болохоор дэмжих, төрийн зүгээс хүмүн капиталын боловсролд оруулж байгаа хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх талаар хийж байгаа судалгаа шинжилгээний ажлыг тууштай үргэлжлүүлэх шаардлагатай байна. Монгол улсын зах зээлийн эдийн засагт шилжих явцад материаллаг үйлдвэрлэлийн салбараас гээгдсэн мэргэжилтэн мэргэжилтэй ажилчдыг буцаан татах, давтан сургах гадаадад суралцаж мэргэжил дээшлүүлж байгаа боловсон хүчний нөөцийг уян хатан бодлогоор зохицуулах нь хүмүн капиталын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх нөхцөл мөн.